



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/423

Арвайхээр

**Малын генетик нөөцийн төлөв байдлыг
тодорхойлох, үнэлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлыг санхүүжүүлэх тухай” 2019 оны А/133 дугаар тушаалын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Улсын төсвийн санхүүжилтээр аймгийн нийт мал сүргийн 1 хувь буюу адуу 3240, тэмээ 1550, үхэр 1720, сарлаг 5000, хонь, 22640, ямаа 20460, нийт 54610 толгой малын генетик нөөцийн төлөв байдлын тодорхойлох, үнэлэх ажлыг 2019 оны 6 дугаар сарын 13-наас 10 дугаар сарын 1-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлыг Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжээр гүйцэтгүүлж, зохион байгуулалт, төсөв, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, тайланг нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

4. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох үнэлгээнд хамрагдах малын тоог өрх бүрээр гаргах, ээмэгжүүлэх ээмэгний зардлыг малчнаар гаргуулах, ажлын хэсгийг ажиллах нөхцөл бололцоогоор хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг бологсугай.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100704

Аймгийн Засаг даргын 2019 оны 06
дугаар сарын 11 ны өдрийн 1123 дугаар
захирамжийн хавсралт



**МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ,
ҮНЭЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ
АЖЛЫН ХЭСЭГ**

**Ажлын хэсгийн ахлагч: С.Цэдэнбалжир -аймгийн Засаг даргын дэргэдэх
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга**

**Нарийн бичгийн дарга: Б.Цэнгэл -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс,
хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга**

**Гишүүд: С.Бат-Эрдэнэ -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж
ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн
Ж.Энхтуяа -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн
газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн
Э.Ёндонсамбуу -аймгийн Мал зүйч үржүүлэгчдийн холбооны
тэргүүн (зөвшилцсөнөөр)
Сумдын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн Мал
аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, үржил, бүртгэл, хариуцсан
мэргэжилтэн**

-оОо-